

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшин гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/871  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал О. Баярбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн тамирчид болон энгийн амрагчийн нэг өдрийн амралтын төлбөрийг тогтоож холбогдох дээд байгууллагаар батлуулах, мөрдөж ажиллах, ашиглалтын хугацаа дууссан, дахин хэрэглэх боломжгүй тоног төхөөрөмж бусад үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандаж шийдвэрлүүлэх, хоол үйлдвэрлэлийн технологийн картыг боловсруулан мөрдөж ажиллах, хоолны менюг 7 хоногоор гаргаж биелэлтэд нь хяналт тавьж ажиллах, НДШ, ХХОАТ-ыг холбогдох хууль, журмын суутган тооцож төсөвт төвлөрүүлж байх, бэлэн мөнгөний кассын орлого, зарлагын баримтыг дугаарлах, гүйлгээ тус бүрээр буюу мөнгө тушаагч бүрээр орлогын баримт үйлдэж нэг хувийг үйлчлүүлэгчид өгч байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 12-аас 2020 оны 3 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ҮАГ-ын захиалгаар Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Сарантуяа, аудиторын туслах П.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн А/103 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол улсын биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод тусгасан зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилалтыг хийхэд ая тухтай нөхцөл бололцоогоор хангах, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Спортын бэлтгэлийн төв ТӨҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний шигшээ багийн бэлтгэл цугларалтыг, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг хангах.
- Үндэсний шигшээ багийн бэлтгэл цугларалтыг зохион байгуулахад үйлчилгээ үзүүлэх.
- Спортын хороо, клубын захиалгаар бэлтгэл цугларалтыг зохион байгуулж үйлчилгээ үзүүлэх.
- Иргэдэд амралтын үйлчилгээ үзүүлэх.
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Хууль тогтоомжоор хориглоогүй бусад аж ахуйн ажиллагаа хэрэглэх.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтгүй, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа одоогоор ямар нэгэн программ хангамж ашигладаггүй байна.

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ -ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд 12 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.5 сая төгрөгөөр буурсан байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.2	4.4	3.2
Авлага	15.0	3.5	-11.5
Бараа материал	32.9	21.1	-11.7
Үндсэн хөрөнгө	955.5	974.0	18.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1004.6</b>	<b>1003.1</b>	<b>-1.5</b>
Өр төлбөр	174.7	176.8	2.0
Эздийн өмч	1172.1	1237.8	65.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1004.6</b>	<b>1003.1</b>	<b>-1.5</b>

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх авлага дансны үлдэгдэл буурсан нь 2017, 2018 онд үүссэн нийт 11.5 сая төгрөгийн авлагуудыг 2018 оны аудитын зөвлөмжийн дагуу тооцоо нийлсэн актаар нөхөн баталгаажуулж, холбогдох хувь хүмүүс болон компаниудаас шаардаж төлүүлсэнтэй холбоотой байна. 2019 оны эцэст амралтын хөлсний 3.5 сая төгрөгийн авлага үлдсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 11.7 сая төгрөгөөр буурсан нь Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-н захирлын 2019 оны 12 сарын 18-ны 16 тоот тушаалаар ашиглалтын хугацаа дууссан, эдийн засгийн хувьд үр ашиггүй, засаж сэлбэх зориулалтаар ашиглах боломжгүй болсон 103 нэр төрлийн 13.0 сая төгрөгийн бараа материалыг тооллогын дүнгээр акталж данснаас хассантай холбоотой. Зарим үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тогтоож элэгдлийн зардлыг алдаатай тооцсоныг залруулсан, мөн 2018 онд төсвийн хөрөнгөөр хийгдсэн 65.6 сая төгрөгийн их засварын дүнг аудитын зөвлөмжөөр санхүүгийн тайланд нөхөж капиталжуулан тусгасан зэргээс шалтгаалж үндсэн хөрөнгийн үлдэгдэл 18.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Өр төлбөрийн үлдэгдлийн өөрчлөлтийг авч үзвэл татварын албанд өгөх өглөгөөс бусад өглөгүүд нийт 23.5 сая төгрөгөөр буурсан бөгөөд үүний дотор цалингийн өглөг 6.4 сая төгрөгөөр, харилцагч байгууллагад өгөх өглөг 5.6 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 8.9 сая төгрөгөөр тус тус буурчээ. Харин татварын албанд өгөх өглөг 25.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалтын орлогын есөлтөөс хамааралтайгаар НӨАТ 12 сая төгрөгөөр нэмэгдсэн бол татварын албанаас 2018 онд хийсэн татварын хяналт шалгалтаар оногдуулсан үл хөдлөх хөрөнгийн 17 сая төгрөгийн албан татварын нөхөн төлбөрийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг нөхөж тусгасантай холбоотой байна.

2019 оны 12 сарын 31 ний байдлаар өр төлбөрийн дансны үлдэгдэл 176.8 сая төгрөг үлдсэнийг задалж үзвэл дараах байдалтай байна:

**Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны  
санхүүгийн тайлангийн аудит**

№	Харилцагч	Өглөгийн утга	Дүн
1	ЭБЦТС ТӨХК	Цахилгаан эрчим хүчний төлбөр	71.4
2	Чэс газ ХХК	Хүнсний хэрэгцээний газ	4.0
3	Хүнсний бөөний төв	Хүнсний материал	1.1
4	Ашид билгүүн ХХК	Дахин үнэлгээний хөлс	0.9
5	Булган аймгийн татварын хэлтэс	Татварын төлбөр	50.7
6	Булган аймгийн НДХ	НДШ-ийн өглөг	20.1
7	Ажилтнууд	Цалингийн өглөг	26.7
8	Хувь хүмүүс	Бусад өглөг	1.9
	<b>Дүн</b>		<b>176.8</b>

Ажилтнуудад өгөх цалин, НДШ, татварын өглөг, цахилгаан эрчим хүчний төлбөр зэрэг нь 3-5 жил хуримтлагдсан өр төлбөр байна.

## **2.9. Зорилтот түвшин гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг бөгөөд 2018 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас Дүгнэлт өгөхөөс татгалзсан, мөн тус байгууллага нь 2019 онд БСШУСЯ-ны харьяа төрийн өмчит үйлдвэрийн газраас Төрийн захиргааны төв байгууллага болох Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяанд шилжих үйл явцтай холбоотойгоор 2018 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх, дүн шинжилгээ өгөх, 2019 оны төсвийг батлуулах үйл ажиллагаа хийгдээгүй хоцорсон байна.

Иймээс 2018, 2019 онуудын орлого зардлын гүйцэтгэлийг харьцуулж харуулав.

### **Хүснэгт 2. Орлого**

Орлогын төрөл	2018 он	2019 он	Өсөлт	/сая төгрөг/
				Өсөлтийн хувь
Үйл ажиллагааны орлого	88.2	128.6	40.4	45.9
<b>Нийт дүн</b>	<b>88.2</b>	<b>128.6</b>	<b>40.4</b>	<b>45.9</b>

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны орлого өнгөрсөн жилтэй харьцуулахад 45.92 хувь буюу 40.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь спортын холбоодын гэрээний үнийн өсөлтөөс гадна 2018 онд санхүүгийн ажилтангүй, энгийн амрагчдын бэлнээр тушаасан амралтын мөнгийг касст орлогоор бүртгэлгүй шууд үйл ажиллагааны зардалд зарцуулдаг байсныг аудитын зөвлөмжийн дагуу 2019 онд кассын орлого болон зардлыг бүртгэлд тусган хяналт тавьж эхэлсэнтэй холбоотой байна.

### **Хүснэгт 3. Зардал**

№	Зардлын үзүүлэлтүүд	2018 оны зарцуулалт	2019 оны зарцуулалт	Өсөлт	/сая төгрөг/
					Хувь
1	Үндсэн цалин	27.8	29.1	1.3	4.6
2	ЭМНД Шимтгэл	3.3	4.2	0.8	24.6
3	Ашиглалтын зардал	5.1	14.2	9.1	181.0
4	Бичиг хэрэг	0.4	0.4		
5	Шатахуун, шатах тослох материал	4.8	3.3	(1.5)	(31.6)
6	Томилолт		2.2	2.2	
7	Бараа материал	25.2	42.6	17.4	68.8
8	Бусад	50.6	33.0	(17.6)	(34.7)
9	Татвар хураамж	9.0	8.2	(0.8)	(8.9)
10	Элэгдлийн зардал	62.2	48.0	(14.2)	(22.9)
	<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>188.3</b>	<b>185.0</b>	<b>(3.3)</b>	<b>(1.8)</b>



2019 оны зардлын гүйцэтгэлийг 2018 онтой харьцуулахад 3.3 сая төгрөг буюу 1.8 хувиар буурсан байна. Зардлын нэр төрлийг авч үзвэл цалингийн зардал 1.3 сая төгрөгөөр өссөн нь гэрээт ажилчдын цалинг бүртгэлд тусгадаггүй байсныг нөхөж тусгасантай холбоотой. Бараа материалын зардал 17.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2018 онд хүнсний түүхий эдийн зарцуулалтыг бусад гэсэн буруу зардлын ангиллаар бүртгэж байсныг залруулсан. Барилга байгууламжийн ашиглалтын хугацааг алдаатай тогтоосон байсныг залруулснаар элэгдлийн зардал 14.2 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт дүнгээр нь 2019 оны үйл ажиллагааны үр дүнг 2018 оны үр дүнтэй харьцуулахад Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь 2019 онд 25.1 сая төгрөгөөр алдагдлыг бууруулж ажилласан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд шинээр 3 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 152.4 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 142.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж 9.4 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байхыг зөвлөмж өглөө. Үүнд:

1. Хүнсний бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайланд 1.7 сая төгрөгөөр илүү тусгагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дүгээр заалт "Аж ахуйн нэгж байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална"-д нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын үлдэгдлийг санхүүгийн тайланд залруулсан.

2. НӨАТ-ын тайланд тусгагдсан 2019 оны нийт орлогын дүн нь орлогын дэлгэрэнгүй тайланд тусгагдсан байгууллагын тайлант жилийн нийт орлогын дүнгээс 57.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Ерөнхий нягтлан бодогч нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НӨАТ-ын тайланд борлуулалтын орлогыг нөхөж тусгасан.

3. Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь 2019 оны бараа материал, хангамжийн зүйлсийн тооллогоор актлагдсан 13.0 сая төгрөгийн бараа материалыг бүртгэлээс хасаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-д "Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээг заавал тусгана" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг залруулсан

3. Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь 2019 оны жилийн эцсийн 64.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт бусад баримтаар баталгаажуулаагүй, холбогдох эзэн холбогдогч нь тодорхой бус байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Ерөнхий нягтлан бодогч нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх"-ыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн задаргааг тодруулж тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг нөхөж баталгаажуулсан.

4. Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь 2019 онд худалдаж авсан цаашид үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой 1.3 сая төгрөгийн гал тогооны хэрэгслүүдийг бараа материал данснаас хасч зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Аж ахуйн нэгж байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална"-д нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгүүдийг санхүүгийн тайланд буцаан орлогод авч санхүүгийн тайланг залруулсан.

4. Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг алдаатай тогтоосноос элэгдлийн зардлыг 4.8 сая төгрөгөөр илүү байгуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дүгээр заалт "Аж ахуйн нэгж байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална"-д нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгүүдийг санхүүгийн тайланд буцаан орлогод авч санхүүгийн тайланг залруулсан. Дахин ийм зөрчил гаргахгүй байхыг анхааруулсан.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2020 оны аудитаар авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Аудитын зөвлөмжийн дагуу 2018 онд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг үнэлгээний компанитай гэрээ байгуулж нөхөж хийлгэсэн дүнг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн 2020 оны А-1/178 дугаар албан бичгийн дагуу 2020 оны санхүүгийн тайланд тусгасан эсэх;
2. Спорт бэлтгэлийн төв ТӨААТҮГ нь спортын улсын шигшээ багийн баг тамирчдын бэлтгэлийг хангуулах зорилгоор зөвхөн дулааны улиралд ажилладаг, 2016 оноос аж ахуйн тооцоонд шилжсэн сүүлийн 4 жилийн хугацааны дундаж үзүүлэлтийг авч үзэхэд жилд 105.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 168.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл алдагдлын дүн жилд дунджаар 62.7 сая төгрөгөөр нэмэгдэж 2019 оны 12 сарын 31 ний байдлаар 411.5 төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай, 175.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

"Спортын бэлтгэлийн төв" ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

"Спорт бэлтгэлийн төв" ТӨААТҮГ нь 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 албан шаардлагыг биелүүлж, 4 зөвлөмж өгснөөс 2-ыг нь хэрэгжүүлж 2 нь хэрэгжих шатандаа байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хуулийн дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Үйлчилгээний үнэ тарифтай холбоотой асуудал**

##### **3.1.1. Илрүүлэлт:**

“Спортын бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь тамирчид болон энгийн амрагчдын нэг өдрийн үйлчилгээний үнийн батлагдсан тариф байхгүй, үйлчлүүлэгч нараас өөр өөр үнээр үйлчилгээний үнийг тооцон авч байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.5 дугаар заалт “Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэл нь хэмжигдэхүйц байх зарчмыг баримтална”-ыг зөрчиж санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Үйлчилгээний орлогыг зүй бусаар зарцуулах, үйлчилгээний өртгөөс бага үнээр үйлчилгээ үзүүлж алдагдал хүлээх,

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Тамирчид болон энгийн амрагчийн нэг өдрийн амралтын төлбөрийн тариф тогтоож холбогдох дээд байгууллагаар батлуулах, мөрдөж ажиллах

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийн дагуу үйлчилгээний үнэ тарифийг тогтооно.

#### **3.2. Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1. Илрүүлэлт:**

2019 онд үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооллогын үр дүн, холбогдох баримт материалыг ТӨБЗГ-т хүргүүлж үндсэн хөрөнгийг данснаас хасах тухай албан ёсны шийдвэрийг гаргуулаагүй байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2 д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу ТӨБЗГ-т тавьж

шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчиж санхүүгийн тайлангийн Оршин байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 3.2.2. Эрсдэл

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дүн алдаатай илэрхийлэгдэх, холбогдох заавар журмыг мөрдөж ажиллаагүй байх.

### 3.2.3. Зөвлөмж

Ашиглалтын хугацаа дууссан, дахин хэрэглэх боломжгүй тоног төхөөрөмж бусад үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах асуудлыг ТӨБЗГ-т хандаж шийдвэрлүүлэх, Үндсэн хөрөнгийн тооллогын дүнг баримтжуулж ТӨБЗГ-аар хянуулан шийдвэр гаргуулж тооллогын үр дүнг 2020 оны санхүүгийн тайланд тусгах

### 3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

## 3.3. Зардлын данстай холбоотой асуудал

### 3.3.1. Илрүүлэлт

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын гал тогоогоор үйлчлүүлж байгаа тамирчид болон энгийн амрагчдад бэлтгэх хоолны цэсийг урьдчилан гаргаж батлуулдаггүй, бэлтгэсэн хоолны хүнсний бүтээгдэхүүний зарцуулалтыг технологийн картаар тооцож хяналт тавьдаггүй, хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авсан хэмжээгээр зардалд бичиж байна.

### 3.3.2. Эрсдэл

Хүнсний бүтээгдэхүүний үргүй зардал гарах, хоолны амт чанар доголдох, хүнсний бүтээгдэхүүний худалдан авалт болон зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих боломжгүй байх;

### 3.3.3. Зөвлөмж

Хоол үйлдвэрлэлийн технологийн картыг боловсруулан мөрдөж ажиллах, хоолны менюг 7 хоноогоор гаргаж биелэлтэд нь хяналт тавьж ажиллах;

### 3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

## 3.4. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал.

### 3.4.1. Илрүүлэлт

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дүн нь нийгмийн даатгалын тайлан, НДХ-тэй тооцоо нийлсэн актын дүнгээс 3.5 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

### 3.4.2. Эрсдэл

Ажилтнуудын болон ажил олгогчийн төлсөн НДШ баталгаажихгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

### 3.4.3. Зөвлөмж

Нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох заавар журмын дагуу үнэн зөв тооцож тайлагнаж байх, НДХ-тэй тайланг тулган, үлдэгдлийг баталгаажуулах

3.4.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

## 3.5 Бэлнээр тушаагдаж байгаа үйлчилгээний хөлсний тухай

### 3.5.1 Илрүүлэлт

Гэрээний дагуу амарч байгаа тамирчдаас бусад үйлчлүүлэгчдээс бэлнээр тушаасан 4.4 сая төгрөгийн үйлчилгээний хөлсийг хурааж авахдаа тухай бүр харилцагч тус бүрээр бэлэн мөнгөний орлогын баримт үйлдээгүй, 7-14 хоногт нэг удаа "Амрагчийн орлого" нэрээр нийт амрагчдын төлсөн мөнгийг бөөн дүнгээр нь баримт үйлдэн касст тушаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 13.7д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

### 3.5.2. Эрсдэл

Үйлчилгээний орлогыг касст бүрэн тушаагаагүй байх, мөнгөн хөрөнгийг зүй бус зарцуулалт гарах.

### 3.5.3. Зөвлөмж

Бэлэн мөнгөний кассын орлого, зарлагын баримтыг дугаарлах, гүйлгээ тус бүрээр буюу мөнгө тушаагч бүрээр орлогын баримт үйлдэж нэг хувийг үйлчлүүлэгчид өгч байх, Бэлэн мөнгөний кассын тооллогыг тухай бүр хийж үлдэгдлийг баталгаажуулж байх

3.5.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

## 3.6 Зардлын данстай холбоотой асуудал

### 3.6.1. Илрүүлэлт

2019 онд хөдөлмөрийн түр гэрээ байгуулсан ажилтнуудын цалингаас 1.8 сая төгрөгийн НДШ-ийг суутгаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасныг зөрчсөн байна

### 3.6.2. Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НДШ, ХХОАТ-ыг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй байх, нөхөн төлбөр, хүү торгууль оногдох;

### 3.6.3. Зөвлөмж

НДШ-ийг холбогдох хууль, журмын суутган тооцож төсөвт төвлөрүүлж байх;

3.6.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,230,868.85	4,439,895.85
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	15,023,750.00	3,500,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	32,855,796.00	21,127,979.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	49,110,414.85	29,067,874.85
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	<b>955,469,001.21</b>	<b>973,986,229.93</b>
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	955,469,001.21	973,986,229.93
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,004,579,416.06	1,003,054,104.78
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг	33,065,630.50	26,662,640.77
2.1.1.3	Татварын өр	25,146,811.96	50,665,643.47
2.1.1.4	НДШ-ийн өглөг	29,108,109.34	20,145,452.02
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	690,451.00	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	86,727,498.00	79,284,042.75
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	174,738,500.80	176,757,779.01
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>174,738,500.80</b>	<b>176,757,779.01</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч-төрийн	<b>1,172,141,788.84</b>	<b>1,237,758,937.84</b>
2.3.2	Өмч-хувийн		
2.3.3	Өмч-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны  
санхүүгийн тайлангийн аудит

2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-342,300,873.58	-411,462,612.07
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>829,840,915.26</b>	<b>826,296,325.77</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,004,579,416.06</b>	<b>1,003,054,104.78</b>

#### 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>88,150,454.55</b>	<b>128,633,682.73</b>
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		42,553,698.19
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>86,079,984.54</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	146,506,886.62	123,702,452.94
10	Ерөнхий ба удирдлагын зардал	16,559,500.91	15,980,812.30
11	Санхүүгийн зардал	25,241,767.00	390,000.00
12	Бусад зардал	3,363.64	1,023,462.81
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-100,161,063.62</b>	<b>-55,016,743.51</b>
<b>19</b>	<b>Орлогын татварын зардал</b>		
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-100,161,063.62</b>	<b>-55,016,743.51</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-100,161,063.62</b>	<b>-55,016,743.51</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-100,161,063.62	-55,016,743.51
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		



#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>82,905,951.00</b>	<b>94,818,000.00</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	82,905,000.00	94,818,000.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	951	
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	82,057,960.95	144,647,373.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	19,195,013.00	30,145,038.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		10,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	43,921,604.00	55,416,190.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,512,315.00	14,004,200.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,111,439.00	3,594,310.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		390,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		3,748,336.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	11,317,589.95	27,349,299.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>847,990.05</b>	-49,829,373.00
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		55,980,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		55,980,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8	Бусад мөнгөн орлого		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		2,439,600.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		898,200.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		1,541,400.00
2.2.6	Бусад мөнгөн зарлага		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		53,540,400.00
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		6,180,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		6,180,000.00

Спортын бэлтгэлийн төв ТӨААТҮГ-ын 2019 оны  
санхүүгийн тайлангийн аудит

3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад мөнгөн орлого		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		6,682,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		6,682,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5	Бусад мөнгөн зарлага		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>-502,000.00</b>
4	Валютын ханшийн зөрүү		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>847,990.05</b>	<b>3,209,027.00</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>382,878.80</b>	<b>1,230,868.85</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,230,868.85</b>	<b>4,439,895.85</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

				/төгрөг/
№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,163,939,288.84</b>	<b>-241,602,418.29</b>	<b>922,336,870.55</b>
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
3	Залруулсан үлдэгдэл			
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			
5	Бусад дэлгэрэнгүй орлого			
6	Өмчид гарсан өөрчлөлт			
7	Зарласан ногдол ашиг			
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
9	<b>2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>1,172,141,788.84</b>	<b>-342,300,873.58</b>	<b>829,840,915.26</b>
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-14,144,994.98	-14,144,994.98
11	Залруулсан үлдэгдэл	1,172,141,788.84	-356,445,868.56	815,695,920.28
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-55,016,743.51	-55,016,743.51
13	Бусад дэлгэрэнгүй орлого			
14	Өмчид гарсан өөрчлөлт	65,617,149.00		65,617,149.00
15	Зарласан ногдол ашиг			
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
17	<b>2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>1,237,758,937.84</b>	<b>-411,462,612.07</b>	<b>826,296,325.77</b>

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020-03-11	Аудитын нэр: <b>Спортын бэлтгэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код: САГ-2020/31/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аудитаар илэрсэн зөрчлийн хураангуй тайлан	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үйлчилгээний батлагдсан үнэ тариф байхгүй, өөр өөр үнээр үйлчилгээний үнийг нэхэмжилдэг		Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
2	Үндсэн хөрөнгийн тооллогын дүнг ТӨБЗГт хүргүүлж шийдвэр гаргуулаагүй		Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
3	Хүнсний бүтээгдхүүний зарцуулалтыг меню болон технологийн картаар тооцож хяналт тавьдаггүй		Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
4	НДХтэй хийсэн үлдэгдлийн тооцоо нийлсэн актны дүн санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй	3.5	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
5	Бэлнээр тушаагдсан амралтын мөнгийг амрагч тус бүрээр бус багцалсан дүнгээр касст баримт үйлдэж тушаасан	4.4	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
6	Гэрээт ажилчдын цалингаас НДШ суутгаж тооцөөгүй	1.8	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	О.Баярбат, О.Батдэлгэр
	<b>Дүн</b>	<b>9.7</b>			